

ТАНИЛЦУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Мөнх Даатгал компанийн үйл ажиллагаатай танилцаж буй эрхэм таны энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Манай компани 2004 онд байгуулагдсан цагаасаа эхлэн харилцагчдадаа мэргэжлийн ёс зүйтэй даатгалын үйлчилгээг тогтмол үзүүлсээр ирсэн бөгөөд 2019 онд компанийнхаа стратегид өөрчлөлт оруулж, өдрөөс өдөрт өсөн дэвшиж буй Монголын даатгалын зах зээлд өөрийн гэсэн шинэ өнгө төрхийг бий болгон, байр сууриа өргөжүүлэн тэлж, Улаанбаатар хот болон 21аймаг, 330 суманд салбар, төлөөлөгчийн газраа байгуулан Монгол улсын өнцөг булан бүрт даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Даатгалын салбар нь харилцагчдынхаа эрүүл мэнд, амь нас,

эд хөрөнгө, хариуцлагыг хэрэгтэй цагт нь учирч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг хариуцлагатай салбар тул бид харилцагчдадаа хамгийн чанартай, хэрэгцээ шаардлагад нь тохирсон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг тусгайлан гаргаж ажилладаг. Бид Улаанбаатар хотын завгүй амьдрал, стресснээс харилцагчдаа ангид байлгах үүднээс технологийн сайжруулалт хийж онлайн даатгал, онлайн нөхөн төлбөрийн үйлчилгээ, 24 цагийн шуурхай дуудлагын үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Бидэнд итгэл хүлээлгэн, эрсдэлгүй ирээдүйн төлөө хамтдаа урагшилж буй нийт даатгуулагч, харилцагч та бүхний ажил үйлс тань амжилт бүтээлээр дүүрэн байх болтугай.

Хүндэтгэсэн,

Мөнх Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал

М.Жалавдорж

A stylized handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke extending to the right.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Мөнх Даатгал ХХК нь 2004 оноос эрдийн даатгалын хэлбэрээр даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулж ирсэн 100% үндэсний хөрөнгө оруулалттай даатгалын компани юм.

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан 11 хэлбэрийн 46 даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол орон даяар 21 аймгийн салбар, даатгалын төлөөлөгчөөр дамжуулан монгол орны өнцөг булан бүрд хүртээмжтэйгээр харилцагч, даатгуулагч нартаа хүргэн ажиллаж байна.

Бидний үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй өргөжин, хураамжийн орлогын өсөлтөөр салбартаа тэргүүлж байгаа нь харилцагч, даатгуулагчдаа дээдлэн, тэдэнд учрах эрсдэлээс бүрэн хамгаалан ажилласны үр дүн юм.



Алсын хараа

Мэргэжлийн ур чадвар, хувиршгүй ёс зүйгээр манлайлж, тогтвортой үйлчилгээгээр даатгалын салбарын хөгжлийг түүчээлнэ.



Эрхэм зорилго

Хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд тулгуурласан, бодитой, хариуцлагатай үйлчилгээ нэвтрүүлж, дэлхийн жишигт нийцсэн ур чадвараар үйл ажиллагаагаа тасралтгүй өргөжүүлнэ.



Үнэт зүйл

- Мэргэжлийн, ёс зүйт, эв эетэй хамт олон
- Мөнхөд хамтдаа даатгуулагч, харилцагч
- Эрүүл ашиг, бодитой хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч
- Хариуцлагатай найдвартай түншлэгч

ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

M

MASTERFUL

Мэргэжлийн түвшинд ажиллана

U

UNITY

Эв нэгдэлтэйгээр нэг зорилгын дор оршино

N

NOBLE

Язгуур, дээд чанарт тэмүүлнэ

K

KNOWLEDGEABLE

Мэдлэгийг эрхэмлэн дээдэлнэ

H

HARDWORKING

Хөдөлмөрч, тууштай сэтгэлээр зүтгэнэ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

2004

“Мөнх Даатгал ХХК” үндэсний 100%-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдав.



ДАВХАР ДААТГАЛ

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн чадавх өндөр давхар даатгалын компаниуд болон дотоодын давхар даатгалын компанид эрсдэлийнхээ тодорхой хувийг даатгуулдаг.



hannover re



MONGOLIAN RE

Үндэсний давхар даатгал ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нэртэйгээр байгуулагдсан. Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор Үндэсний давхар даатгал ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн. Тус компанитай 2019 оноос хохирлын хэтрэлтийн давхар даатгалаар хамтран ажиллаж эхлээд байна. 2020 оноос малын болон газар тариалангийн давхар даатгалаар хамтран ажиллаж байна.

HANNOVER RE


Hannover Re компани нь Монголын зах зээлд 2010 оноос хойш идэвхтэй оролцож байгаа давхар даатгагчийн хувьд сайн дурын давхар даатгалын гэрээнд оролцох сонирхолтой байдаг. Иймээс бид гэрээт давхар даатгалын хязгаараас давсан үнэлгээтэй болон тусгайлсан эрсдэлүүдээр тус компанитай харилцаж байна. Сүүлийн 5 жилд гарсан томоохон хохирлуудыг шуурхай нөхөн төлсөн туршлагатай.

MARSH MCLENNAN


Олон улсын томоохон даатгалын брокер компаниуд болох Марш, ЖЛТ компаниуд 2019 оны 4 сард нэгдэж дэлхийд тэргүүлэх компани болсон. Тус брокер нь манай улсад уул уурхайн даатгал болон сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр 2009 оноос эхэлж ажилласан туршлагатай бөгөөд Фронтингийн давхар даатгалаар хамтран ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт хураамж (сая.төг)




Нийт хөрөнгө (сая.төг)




Нөөц сан (сая.төг)




Нөхөн төлбөр (сая.төг)



Даатгуулагчдын тоо (иргэд)



Даатгуулагчдын тоо (байгууллага)




НӨХӨН ТӨЛБӨР ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕСС



Бид нөхөн төлбөрийн материалыг бүрэн гүйцэт хүлээн авснаас хойш даатгалын гэрээнд заасны дагуу түргэн шуурхай шийдвэрлэн олгодог.


НӨХӨН ТӨЛБӨР АВСАН ДААТГУУЛАГЧДЫН ТОО



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Бид үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын туршлагуудыг бүрэн тусгаж, энэ чиглэлээр Компанийн тухай хууль болон засаглалын зарчмуудыг хэрэгжүүлж ажилладаг.

Мөнх Даатгал ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын эрх үүрэг, хариуцлага, санхүү тайлагнахтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар журам, дүрэмдээ маш дэлгэрэнгүй тусгаж, даатгалын салбарын онцлогийг зохицуулсан даатгалын багц дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.





www.munkhdaatgal.mn